



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ
АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ

Гар бичмэлийн эрхтэй ©

МӨНХБОЛДЫН НОМИНГЭРЭЛ

СУВИЛАГЧ МЭРГЭЖИЛТНИЙ АЖЛЫН АЧААЛАЛ,
ХЭТИЙН ТӨЛӨВИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Е 09130101 Сувилахуй

Сувилахуйн ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл

Улаанбаатар хот
2017 он

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРЫН ЯАМ
АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ**

МӨНХБОЛД НОМИНГЭРЭЛ

**СУВИЛАГЧ МЭРГЭЖИЛТНИЙ АЖЛЫН АЧААЛАЛ,
ХЭТИЙН ТӨЛӨВИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ**

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч:

Анагаах Ухааны доктор

О.Болорсайхан

Эрдэм шинжилгээний ажлын зөвлөх:

Анагаах Ухааны доктор

Д.Хишигтогтох

Эрдэм шинжилгээний ажлын шүүмжлэгч:

Анагаах Ухааны доктор

С.Мягмарчулуун

Улаанбаатар хот

2017 он

Хураангуй

Түлхүүр үг: сувилагчийн ажлын ачаалал, хэтийн төлөв

Сэдэв: Сувилагчийн ажлын ачаалал, хэтийн төлөвийг тодорхойлох нь

Үндэслэл: Сувилахуй нь эрүүл мэндийн салбарын томоохон бүрэлдэхүүн бөгөөд сувилагч мэргэжилтэн энэ салбарт голлох байрыг эзэлж, сувилахуйн тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэх нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах хүчин зүйл болдог.¹ Манай орны хувьд ч мөн тулгамдсан асуудлын нэг болоод байгаа учир бид энэхүү судалгааг хийх үндэслэл боллоо.

Зорилго: Сувилагч мэргэжилтний ажлын ачааллыг үнэлж, хэтийн төлөвийг тодорхойлох.

Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн ба арга зүй: Уг судалгааг эмнэлэгт суурилсан аналитик судалгааны нэг агшингийн загвараар гүйцэтгэв. Судалгааны хамрах хүрээ нь эмнэлгийн тусламжийн анхан, лавлагаа шатлалд ажиллаж буй сувилагч нар байсан ба түүвэрлэлтийг хийхдээ санамсаргүй түүврийн аргаар, зарим төрөлжсөн мэргэжлийн сувилагч нарыг зориудын түүврийн аргаар сонгож судалгаанд 32 байгууллагын 22 төрлийн мэргэжлийн 179 сувилагчийг хамруулсан. **Байгууллагад суурилсан ажиглалтын** аргаар мэргэжил тус бүрээр (1) сувилагч мэргэжилтний ажлын ачаалал, (2) ажлын ачааллыг "Ажлын үнэлгээ"-ний шалгуур, баримт, ажиглалтын аргаар мэдээ мэдээллийг цуглуулсан. Мэдээллийн үр дүнгийн боловсруулалтыг хийхдээ тоон мэдээлэлд SPSS 17.0 программ, хронометрийн болон ажлын үнэлгээний үр дүнд дескриптив шинжилгээ хийж ажилласан хугацаа, ажлын төрлүүдэд зарцуулсан хугацааны, ажлын үнэлгээний 16 шалгуур үзүүлэлт тус бүрийн дундаж утга, голч утга, хамгийн их, бага утгыг тооцож үр дүнг гаргав. Сувилагчийн хэтийн төлөвийг тооцохдоо: Хугацааны цувааг шинжлэх аргаар регрессийн шинжилгээ хийж үнэн магадлалыг тооцоолон ARIMA загварыг ашиглан тооцож тодорхойлсон.

Судалгааны үр дүн: Судалгаанд Улаанбаатар хот болон аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж байгаа нийт 179 сувилагчийг хамрууллаа. Эдгээрийн дийлэнх нь буюу 77,7 % нь лавлагаа шатлал, 22.3% нь анхан шатлалын эмнэлгээс судалгаанд хамрагдсан. Сувилагч нь өдөр тутмын ажилд дунджаар 447 минутыг зарцуулж байна. Анхан шатлалын сувилагч нь бусад шатлалаас олон

үйлчлүүлэгчдэд сувилахуйн тусламж үйлчилгээг хүргэж (23.0 үйлдлийг гүйцэтгэж) байгаа боловч тусламж үйлчилгээнд зарцуулах нийт хугацаа анхан шатлалаас (234.0), лавлагаа (276.0) шатлалд нэмэгдсэн үр дүнтэй байв. Сувилагчийн ажлын ачаалал III-V зэрэглэлд ангилагдсан бөгөөд шатлалын хувьд анхан шатлал III-IV зэрэглэлд, лавлагаа шатлал III-V зэрэглэлд ангилагдав. Сувилагч мэргэжилтний сүүлийн 10 жилийн мэдээлэл дээр тулгуурлан 2020 он хүртэлх сувилагчийн тоо 13061 (CL 95% итгэх интервацийн бага утга 11330.6, их утга 14791.7) болж нэмэгдэх, 2024 онд 13626.8 (CL 95% итгэх интервацийн бага утга 9743.7, их утга 17509.9) болж нэмэгдэх хандлага бүхий үр дүн гарсан. Харин 2017-2021 он хүртэл хугацаанд эмч сувилагчийн харьцаа 1:1.2 болон нэмэгдэх хандлагатай байгаа ч 2022-2024 онд буурч эмч сувилагчийн харьцаа 1:1.16 болох төлөв байна. Нэг сувилагчид ногдох хүн амын тоо сувилагчийн өсөлт, хүн амын өсөлтөөс хамаарч аажмаар буурч 2024 онд нэг сувилагчид ногдох хүн ам 249.5 болох үр дүн гарлаа.

Судалгааны дүгнэлт:

1. Хот, хөдөөгийн сувилагчийн өдөр тутмын ажлын ачаалал хугацааны хувьд төстэй, дунджаар 447 минутыг зарцуулж байна. Анхан шатлалын сувилагч олон үйлчлүүлэгчид эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэж (23.0 үйлдлийг гүйцэтгэж) байгаа боловч тусламж үйлчилгээнд зарцуулах нийт хугацаа анхан шатлал(234.0)-аас лавлагаа (276.0) шатлалд нэмэгдэх хандлагатай байна. Ажлын үнэлгээгээгээр сувилагчийн ажлын ачаалал мэргэжлийн төрөл, эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэл, шатлалаар ялгаатай байгаа боловч сувилагчийн ажлын ачаалал III-V зэрэглэлд ангилагдсан.
2. Сувилагч мэргэжилтний хэтийн төлөвийг 2020 он хүртэл тооцоход сувилагчийн тоо дунджаар 13061, улмаар 2024 онд 13626.8 болох хэдий ч эмч, сувилагчийн харьцаа 1:1.16 болох төлөвтэй байна. Нэг сувилагчид ногдох хүн амын тоо сувилагчийн өсөлт, хүн амын өсөлтөөс хамаарч аажмаар буурч 2024 онд нэг сувилагчид ногдох хүн ам 249.5 болох үр дүн гарлаа.

Abstract

Key words: work overload among nurses, perspective

Title: To determine work overload, perspective among nurses

Background:

Nursery is major component of healthcare field especially nurses account main position to serve professional care and becoming key factor to improve healthcare service. We aimed to initiate our research to study one of the faced problems in our country.

Purpose:

To determine work overload, perspective among nurses

Materials and Methods:

We carried our stud out with hospital based analytic cross-sectional study design. We chose nurses from primary healthcare and referral level and involved 179 nurses of 22 types of specialty professions of 32 companies according to their inclusion framework with data collection of random selection method. We collected work load data with work load of nurses (1) and "evaluation of work" criteria, documents, observation method (2) with each profession. We analyzed chronometric and evaluation result of work with descriptive analyze and calculated mean value, median, minimum and maximum values of total worked period, time spent on work types, 16 criteria of work evaluation with using SPSS 17.0 software. For calculating perspective among nurses: we used regression study with time sequence method to determine significance and determined with ARIMA perspective method.

Results:

We involved 179 nurses who work in healthcare centers of Ulaanbaatar city and rural areas. Nurses spend mean of 447 minutes for daily work. Nurses of primary levels provide healthcare for more clients (23 operations) however time spent on healthcare service in primary level (234.0), referral level (2476.0) has increased. Nurses work load classified as III-IV level and according to its stages it categorized into primary level III-IV and referral level III-V. Considering the result of collected data of nurses in last decades, there is

tendency to increase number of nurses by the year 2020, 13061 (minimum and maximum value of CI 95%-confidence interval 11330.6 and 14791.7 respectively), and by the year 2024 it will be 13626.8 (minimum and maximum value of CI 95%-confidence interval 9743.7 and 17509.9 respectively). But in 2017-2021, there is tendency that could increase the ratio of doctors and nurses 1:1.2 and it may decrease in ratio of 1:1.16 by the year 2022-2024. Increasing population number per nurses will be reduced with relation of population growth and will be 249.5 populations per nurses in 2024.

Conclusions:

1. Work load and time spent for work is similar, 447 minutes, in both urban and rural areas. Nurses of primary level provides healthcare service for more people (23 operations) however their total spent time in primary level (234.0) and referral level (276.0) has tendency to increase. Nurses work load categorized as level III-V even work evaluation of nurse's work load was different in profession type, healthcare service direction and levels.
2. Perspectives among nurses till the year 2020 has estimated mean number of nurses will be 13061, consequently it will be 13626.8 by the year 2024 but the ratio of doctors and nurses will be 1:1.16 . There is a result of population growth per nurses and general population growth will gradually decrease and will be 249.5 populations per nurses in 2024.

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	5
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	6
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	7
УДИРТГАЛ	
Судалгааны ажлын үндэслэл	8
Судалгааны ажлын таамаглал	10
Судалгааны ажлын зорилго, зорилтууд	10
Судалгааны ажлын шинэлэг тал	10
Судалгааны ажлын практик ач холбогдол	10
Судалгааны үр дүнг хэлэлцүүлсэн байдал	11
Судалгааны ажлын бүтэц хэмжээ	11
Судалгааны ажлыг хэвлүүлсэн байдал	11
НЭГДҮГЭЭРБҮЛЭГ. ХЭВЛЭЛИЙН ТОЙМ	
1.1. Сувилахуйн ухааны түүхэн хөгжил	13
1.2. Сувилахуйн салбарын хүний нөөц	15
1.3. Сувилагчийн ажлын ачаалал	16
Хронометрийн арга	17
Ажлын үнэлгээний арга	18
1.4. Сувилагчийн хөгжлийн зураглал, ажлын байрны тодорхойлт	19
1.5. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	21
1.6. Ажлын ачаалалтай холбоотой нэр томъёо	23
1.7. Сувилагчийн ажлын ачаалал, талаар судлагдсан байдал	25
ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БА АРГА ЗҮЙ	
2.1. Судалгааны загвар	26
2.2. Судалгааны хүрээ ба түүвэр	26
2.3. Мэдээлэл цуглуулах арга	27
2.4. Судалгааны мэдээ, дүн шинжилгээ хийх арга	29
2.5. Үр дүнгийн статистик боловсруулалт	33
2.6 Судалгааны ажлын хязгаарлагдмал тал	33

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

3.1. Сувилагчийн ажлын ачаалал, ажлын үнэлгээ 34

3.2. Сувилагч мэргэжилтэний хэтийн төлөв 43

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХЭЛЦЭМЖ 49

СУДАЛГААНЫ АЖЛЫН ДҮГНЭЛТ 56

ЗӨВЛӨМЖ 57

НОМ ЗҮЙ

ХАВСРАЛТ